



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар A/07

Батширээт сум

**Улаанбурхан улаануудын эсрэг
вакцинаар нэмэлт дархлаажуулалт
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Дархлаажуулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Засгийн газрын 2025 оны 08 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын хамтарсан А/484, А/291 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/21 дүгээр тушаал, Хэнтий аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 10-15 насны хүүхдүүдийг Улаанбурхан улаанууд өвчний эсрэг вакцинаар 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн нэмэлтээр дархлаажуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Ж.Энхтөр)-д үүрэг болгосугай.
2. Боловсрол сургалтын байгууллагад суурилсан дархлаажуулалтыг зохион байгуулах тул зорилтот насны хүүхдүүдийг бүрэн хамруулах, дархлаажуулалтын түр цэгийг байгуулах өрөө, тасалгаагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын сургуулийн захирал (Ц.Цогзолмаа)-д үүрэг болгосугай.
3. Нэмэлт дархлаажуулалтын ач холбогдлын талаар мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн зохион байгуулахыг Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (Д.Нямсүрэн), Эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан (Я.Отгончимэг) нарт даалгасугай.
4. Дархлаажуулалтын үйл ажиллагаа, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Ж.Энхтөр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232601013